

Орон бүхний пролетариат нар нэгдэгтүн!

АНХ ДЭГТААР ТАВАНЖИЛ

Төв аймгийн Намын Хороо, А.Д.Х-ын гүйцэтгэх захиргааны сонин

27 дахь жилдээ

№ 59 (2323)

1974 оны 8 дугаар сарын 8

ПҮРЭВ

Түүхт III их хурал

Монголын ард түмэн, анд нөхдийнхөө хамт манай орны хувьсгалт тэмцэлийн түүхэн дэх алдарт үйл явдал МАХН-ын III их хурал хуралдсан боловч БНМАУ-ыг тунхагласны хагас зуун жилийн ойгуудахгүй бодол тэмдэглэх гэж байна.

МАХН-ын III их хурал 1921—1924 онуудад монгол орны нийгэм-эдийн засгийн амьдралд гарсан гүн гүнзгий оорцолтлуудийг дүгнэн БНМАУ-ыг капиталист биш замаар хөгжүүлэх зорилтыг намын жанжин шугам болгон тавьж ардын хувьсгалын хэтийн төлөнийг яруу сайхнаар тодорхойлсон юм.

МАХН-ын III их хурлын тогтоолд "Монгол улс, бүх дэлхийн олон улстай адил хэргийг капиталант хөрөнгөтний дарлал зовлонг үл амсан олон улсын одоогийн байдалд нийлүүлж жинхэнэ ардын ёсыг барилтлан зоривол болов уу гэсэн тухайг хэлэлцээд энэ нэгдсэн хэрэгт ийнхүү зорих нь зүйтэй болох учир бүгдээрээ зовшоорон баталж тогтоо" гэж хувьсгалын хэтийн төлөл, капиталист биш замаар улс орноо хөгжүүлэх зорилтыг тодорхойлжээ.

Ардын хувьсгалаар байлдан олон үндэсний бүрэн эрхт тусгаар тогтносон байдал, ард түмний эрх чөлөөг гадаад дотоодын дайснаас сахин хамгаалж, улс орноо капиталист биш замаар хөгжүүлэх явдлын гол түшиг тулгуур, шийдвэр хүч болоон Монгол-Зөвлөлтийн ард түмний ах дүүгийн найрамдлыг бэхжүүлэхийн чухалыг их хурал онцлон заасан юм. Тус хурал эдийн засгийг цаашид хөгжүүлэх үе хориооолмын байгууллагуудыг бэхжүүлж, гадаадын капиталыг шахан зайлуулах, ардын засаг төрийг бэхжүүлэх талаар чухал шийдвэр гаргасан байна.

Намын зохион байгуулалт, үзэл суртлын ажлыг тавигдаж байгаа зүйл зорилттой уялдуулан эрх дэвшүүлэх, намын эгнээг бэхжүүлэх талаар их хурал зарчмын чухал шийдвэр гаргаж намын жанжин шугамыг эсэргүүцсэн үндэсний капиталист элементийн эрхлэллээд хатуу нохилтыг өгчээ. Монголын ард түмэн яруу алдарт МАХН-ын удирдлагаар тус орныг капиталист биш замаар хөгжүүлэх талаар МАХН-ын III их хурлын түүхт шийдвэрийг хэрэгжүүлэн биелүүлж хүн төрөлхтний хөгжлийн бүхэл бүтэн нэгэн шатыг алгасан социалист, нийгмийг өрнүүлж байгуулах үе хүртэл бүрх боловч яруу алдарт хагас зуун жилийг туулан өнгөрүүлэв. Урьд хоцрогдсон монгол орон капитализмыг алгасан социализмд дэвшин хөгжсөн бодит үйл явц бол Марксист-Ленинзийн сургаалын үнэн зөвийг нотлон түүнийг түүхэн тодорхой нөхцөлд бүтээлчээр хэрэгжүүлсний яруу сайхан жишээ нь болж байна.

МАХН-ын III их хурлын түүхэн шийдвэр, түүнийг хэрэгжүүлэхийн төлөө явуулсан манай намын үйл ажиллагаа, түүний сургаамж туршлага нь орчин үед хүн төрөлхтний нилээд хэсгийг хамарч байгаа үе орнуудын хөгжлийн замаа сонгон авахад нь туслаж байна. Манай нам БНМАУ-д социалист нийгмийг байгуулах түүхэн зорилтыг хэрэгжүүлэх явцдаа олон улсын ач холбогдол бүхий ихээхэн туршлагыг хүрмтгүүлэн Марксист-Ленинзийн эрдэмсний санд үнэт хувь нэмрийг оруулсан юм.

Түүхт ойг угтаж БНМАУ хөгжлийн капиталист шатыг алгасан феодализмыг социализмд шилжих үйлсэд МАХН-ын III их хурал, БНМАУ-ыг тунхагласан анхдугаар үндсэн хууль баталсны түүхэн ач холбогдол, манай хөгжлийн туршлага ардын засгийн жилдүүдэд монголын ард түмний олон асар их амжилт, ЗХУ болон социалист орнуудаас үзүүлж байгаа сэтгэл хараггүй өгөөмөр тусламж социалист орнуудын хамтын ажиллагаа ах дүүгийн найрамдлыг өргөн сурталчлах нь чухал байна. Нийт ард түмний энэ их баярыг хөдөлмөр соёлын өндөр амжилтаар угтаж аж ахуй, соёлын төлөвлөгөөг тоо чацарын өндөр үзүүлэлтээр ханган биелүүлцэгээ.

ШАР ДЭЛИЙН ХАДЛАНЧИД

Эрдэнэсант сумын хэмжээгээр хадлангийн 6 бригад трактор хадуур 14, морин хадуур 9, 130 хүнтэйгээр гарч 1257 га—гаас 503 тонн өвс хадгаад байна. Сумын 13 байгууллагын 159 ажилчин албан хаагчид, мал аж ахуйн 4 бригадын 112 суурийн 500 гаруй малчид 1941 тонн өвс, хүн бүр 300—500 ширхэг зоодой бэлтгэхээр даалгавар аваад ажиллаж байна. Тус сүм-нэгдлийн Угалзат бригадын хадланчид хадлангийн ажилд бусдыгаа хошуучилж байгаагийн дотор хадагч Дагва, Баянмөнх, Намдорж, тармагч Насанбат нар өдөр бүрийн нормоо 100-гаас дээш хувиар биелүүлж социалист уралдаанд тэргүүн байр эзлэж явна.

П. ОЧИРБАТ

ХӨДӨЛМӨР СОЁЛЫН АЯНЫ БАРИАНД

Лүн сумын намын үүр, нэгдлийн зөвлөл, ХЗЭ-ийн хороо, өөрийн шеф Мэдээлэл радио телевизийн улсын хороотой хамтарч өнгөрсөн оны 10 дугаар сард залуучуудынхаа дунд зарласан хөдөлмөр соёлын 10 сарын аяныхаа дүнг гаргахаар сумын залуучуудын хөдөлмөр соёлын чуулга уулзалт зохиов. Чуулга уулзалтад оролцогчдын хурал сумын клубт болж хурлыг намын үүрийн нарийн бичгийн дарга Гончиг нээж үүр хэлсний дараа сумын ХЗЭ-ийн хорооны дарга Л.Батсүх 10 сарын аяны дүнг илтгэлээ. Сумын хүн амын 63,4 хувийг эзэлж байгаа залуус хөдөлмөр соёлынхоо 10 сарын аянд тодорхой зорилт дэвшүүлж, түүнийгээ нэр төртэй хэрэгжүүлжээ.

Сумын нийт малын 61,3 хувийг дан залуучууд харуцан малаж, өнгөрсөн оны дотор нүүдэл хийж мал сүргийнхээ 90,1

хувийг дундаас дээш тарга хүч авахуулж онд сайн оруулсны дүнд 31,9 мянган төл хүлээн авч гарсан төлийн 99,6 хувийг бойжуулжээ.

Улсын төлөвлөгөөнөөс 2400 төл илүү бойжиж байгаагийн гадна төлчин 31 эвлэлийн гишүүнээс 29 нь төлөө 99,3—101,4 хувь бойжуулж залуу малчдыг хошуучилжээ.

Өгөөмөр бригадын хоньчин ХЗЭ-ийн гишүүн Ж. Дашдаваа, илгээлтийн эзэн Ц. Чанцалдулам, П. Долгоржав, Цагаануул бригадын хоньчин С. Даваасүрэн, Б. Баасан, саальчин Б. Цэрэнгаамаа, холбоочин Б. Юмээ, хүний бага эмч Д. Ганбүргэд, буудлын үйлчлэгч Е. Тунгалаг нарын олон залуус 10 сарын аянд авсан үүргээ давуулан биелүүлж уралдааныг хошуучиллаа.

Өгөөмөр бригадын хоньчин, ХЗЭ-ийн илгээлтийн эзэн П. Долгоржав 265

хонингоос 267 төл боёгжуулж нэгдлийн үйлдвэрлэлийн даалгаврыг нэр төрөл дээр нь биелүүлж, Цагаануул бригадын хоньчин, илгээлтийн эзэн Б. Баасан 568 хонингоос 574 төл бойжуулж, бэлтгэсэн ноолуурынхаа 83 хувийг 1, 2 дугаар зэрэгт тушааж тус тус нэгдлийн зардлаар ЗХУ-д жуулчлах, Өгөөмөр бригадын хоньчин Н. Борхүү мал сүргээ хорогдолгүйг онд оруулж төлөө бүрэн бойжуулж уралдааныг бэлдэж ян дагуу нэгдлийн адуун сүргээсээ хамгийн хурдан хөлгийг өөрөө сонгон авах эрхийн бичгээр шагнагдаа. Хөдөлмөр соёлын аянд өндөр амжилт гаргасан ажилчин малчин сэхээтэн 20 залуу нэгдлийн зардлаар Улаанбаатар, Дархан-Сэлэнгийн чиглэлийн тойрэн аялалд оролцох болов.

Тус чуулга уулзалтаас уриалга гаргав.

П.ЖАНЧИВ

ХАДЛАНГИЙН ЯВЦ

Аймгийн хэмжээгээр 8 дугаар сарын 1-ний байдлаар 5,2 мянган тонн өвс бэлтгэж төлөвлөгөөний 5,4 хувийг биелүүлээд байгаагийн дотроос САА 7,3, ХАА-н нэгдлүүд 4,3, ТАА-нууд 2,7 хувьтай байна. Хадсан өвсийг өнгөрсөн оны мөн үетэй харьцуулбал 89,5 хувиар буюу 2,4 мянгаар илүү байна.

Хадлангийн төлөвлөгөөний биелэлтийн сумдаар байр эзлүүлэн үзүүлбэл:

Сумд	Хувь	Байр
Баян-Өнжүүл	19,3	1
Жаргалант	11,8	2
Заамар	11,1	3
Баянцогт	8,9	4
Батсүмбэр	8,6	5
Бүрэн	5,7	6
Мөнгөнморьт	5,5	7
Баян	4,7	8
Борнуур	4,3	9
Өндөрширээт	4,0	10
Сэргэлэн	3,3	11
Дэлгэрхаан	2,6	12
Лүн	2,3	13
Угтаал	2,3	14
Баяндэлгэр	2,2	15
Алтанбулаг	1,9	16
Эрдэнэ	1,7	17
Эрдэнэсант	1,6	18
Баянчандмань	1,6	19
Баянцагаан	1,2	20
Баянзүрх	0,7	21
Баянжаргалан	0	22

Статистикийн товчоо

СҮҮ ТОС БЭЛТГЭЛТ

Аймгийн хэмжээгээр 7 дугаар сарын 30-ны байдлаар улсад тушаах сүүний төлөвлөгөөний 45,8 хувийг гүйцэтгээд байгаа нь өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 3,0 хувиар дээгүүр байна.

Ээдэмцэр тос үйлдвэрлэх төлөвлөгөөний биелэлт 38,2—46,4 хувьтай байна.

Сүү тушаалт, тос ээдэмцэр үйлдвэрлэлийн явцыг сумдаар үзүүлбэл: (хувиар)

Сумдын нэр	улсад тушаах сүү	Үйлдвэрлэлт тос	ээдэмцэр
Алтанбулаг	56,6	—	—
Батсүмбэр	65,7	—	—
Баян	29,6	—	—
Баян-Өнжүүл	—	44,8	35,4
Баяндэлгэр	42,1	—	—
Баянжаргалан	21,3	—	—
Баянзүрх	43,0	—	—
Баянцагаан	—	39,8	8,9
Баянцогт	25,2	—	—
Борнуур	55,8	—	—
Бүрэн	—	55,7	34,8
Дэлгэрхаан	—	77,9	68,3
Заамар	62,3	—	—
Лүн	23,5	—	—
Мөнгөнморьт	75,1	—	—
Өндөрширээт	23,4	—	—
Сэргэлэн	40,9	—	—
Эрдэнэ	39,8	—	—
Эрдэнэсант	—	42,4	43,3
Баянчандмань	58,0	—	—

Сүү тушаалтаар хоцорч яваа Баянжаргалан, Лүн, Өндөрширээт, Баянцогт, Баян зэрэг сумд үлдэж байгаа хугацаанд ажилдаа дүгнэлт хийж ажиллах хэрэгтэй байна.

Статистикийн товчоо



АВАРТЫНХАН МЯНГАН ТОНН ӨВСТЭЙ

Жаргалантын САА-нхан хадланд механикжсан 2 салаа гарган өвс хадах, тармах, бухалдах, зөөх, нурууллах ажлыг нарийн дэс дараалалтай явуулж эхний 10 хоногийн төлөвлөгөөг үлэмж давуулан биелүүлээ.

Тус аж ахуйн хадланчид 1974 оны ургац хураалтын талаар социалист уралдаан өрнүүлэх тухай МАХН-ын Төв Хороо, Сайд нарын Зөвлөл, МҮЭ-ийн Төв Зөвлөл, МХЗЭ-ийн Төв Хорооны тогтоолыг хүлээн аваад хадлангийн машин техникийн хүчин чадлын ашиглалтыг нэмэгдүүлэн дотоод нөөц бололцоог дайчлан техникийн саатлыг 45 хувиар багасгах нэмэлт үүрэг авч идэвх чармайлттай ажиллаж байна.

Улсын хадлангийн аварга бригадын дарга Б.Чойндондорж техникч нэг бүрийн ажил амьдрал, хэн ямар мэргэжил дамжлага дээр ажиллавал илүү үр бүтээл гаргаж чадах зэргийг нарийн мэдэж тэднийг үйлдвэрлэлд хуваардан ажиллуулж байна.

Түүнчлэн хүн нэг бүрийн уралдааныг дүгнэхийн тулд техникчдийн түр цуглааныг өдөр бүр хийж ололт туршлагыг ярьж, хэн ямар шалтгаанаас төлөвлөгөөгөө биелүүлээгүйг тооцон, хийх ажлаа зөвлөж авдагаас

техникчид хариуцлага сахилга бат сайтай ажиллаж байна.

Б.Чойндондоржийн бригадын хоёр салаа өвс хадаж тармах, хаман боож зөөж, нурууллах ажлыг ганц удаагийн явалтаар иж бүрэн хийж байгаагаас сайн чанарын өвс арван мянган боодлыг бэлтгэжээ. Энэ бригадын хоёр салааны тракторчид өвс хадах, тармах, бухалдах, хаман боох, зөөх, нурууллах ажил дээр 5-8 жил дараалан ажиллаж, үйлдвэрлэлийнхээ арга технологи дээр мэргэжил дэдлэгтэй болсны үрээр ажил шуурхай, саатайгүй явагдаж байна.

Ийм ч учраас тус бригадын дугуйт тракторын парк ашиглалт зэргэлдээ САА, нэгдлийн хадланчдын техник эзэмшилтээс илүү байна.

Дөш гэдэг газар хадлан хадаж байгаа Г.Ганбат ахлагчтай механикжсан салаа, трактор хадлуур, тармуур тус бүр 7, хаман боогч 4-тэй ажиллаж ажлын 12 хоногийн төлөвлөгөөг 10 хувиар давуулав.

Тракторчин Балжирдэндэв, Лхагвасүрэн, улсын аварга хадланчин Г.Ганбат, Д.Пүрэвдорж нар өдөр бүрийнхээ үүргийг 150-200 хувь биелүүлж залуу техникчдийг дагуулан өвс хадлангийн арга технологит сургаж байна.

Б.Чойндондоржийн бригад энэ жил 8500 тонн өвс бэлтгэх төлөвлөгөөг 45 хоногт биелүүлэх үүрэг авч одоогийн байдлаар мянгад тонн өвс хаджээ.

Жаргалантын САА-н нам, захиргааны байгууллага нийт хүнийг хадлан гэжээл авах, мал аж ахуйн өвлийн бэлтгэлийг хангахад чиглүүлэн сум тасгийн төвөөс 180 гаруй хүнийг хадлангийн ажилд тусалцуулж байна.

Ногоочин Л. Гансүх, Дашрэнчин, Батсайхан нарын олон ажилчид Г.Ганбатын салаанд туслаж уралдаанд авсан үүргээ өдөр бүр давуулан биелүүлж байна.

О. СҮМЬЯА

„Алтан хаалга“ руу уралдаж байна

Өндөрширээт сумын нам, захиргаа, ХАА-н байгууллага зохион байгуулалтын нилээд арга хэмжээ авч, хадланд 7 дугаар сарын 27-ноос жигдрэн гарчээ.

Сумын хэмжээгээр бүрэн механикжсан бригад 1, хагас механикжсан 4 бригадалд 126 хүн гарч өндөр ургацтай Баргын хоолой, Давхрын Дашгай, Хөшөөнө ухаа зэрэг газруудад хадланд гарч 800-гад тонн өвс аваад байна. Тус сум хадланчдын дунд Монголын радиогийн 40 жилийн ой угтсан урцан дор „Алтан хаалга“ гэсэн сэдэвт уралдаан зарлан өрнүүлж бай-

на. Сум-нэгдлээс хадлангийн бригадуудыг шалгаруулах болзол гаргасны гадна хадланчдын ажлыг өдөр бүр дүгнэн шагнаж урамшил олгож байна.

Саяхан дүгнэсэн уралдаанаар МХЗЭ-ийн гишүүн, улсын аварга хадланч, МХЗЭ-ийн Төв Хорооны алтан медальт Н. Болд түрүүлээ.

Тус сум хадлангийн ажлыг 9 дүгээр сарын 1-ний дотор багтааж дуусгах график төлөвлөгөө гаргаж 6 өдрийн ажлыг 5 өдөрт багтаан биелүүлэх өндөр зорилтыг хадланчдын өмнө дэвшүүлжээ.

Ц. НОРОЛХОО

Таван төрлийн ноос бэлтгэлт (хувиар)

Сумдын нэр	урт ноос	ахар хурга	тэмээ- ний ноос	ямааны ноос	ямааны ноос- луур	байр
Жаргалант	102,5	107,7	3,9 да	2,5 да	2,4 да	1
Баянчандмань	112,0	107,9	115,5	133,3	100,0	2
Батсүмбэр	100,1	56,7	2,0 да	135,2	100,6	3
Баянцогт	99,6	108,8	102,9	105,5	107,5	4
Баянзүрх	100,0	79,3	100,6	100,0	100,3	5
Борнуур	121,5	54,3	—	115,2	124,5	6
Алтанбулаг	88,6	115,1	81,8	69,8	102,8	7
Баянжаргалан	91,1	18,2	80,4	100,1	100,2	8
Заамар	97,7	6,4 да	83,3	92,3	93,2	9
Сэргэлэн	87,7	98,1	85,0	81,6	100,6	10
Баян-өнжүүл	91,0	39,5	87,3	94,8	102,0	11
Угтаал	100,2	94,5	90,2	37,6	84,1	12
Баян	93,8	17,0	80,2	97,2	103,2	13
Баяндэлгэр	84,2	52,2	68,9	78,5	104,0	14
Дэлгэрхаан	81,9	33,5	98,0	72,0	102,0	15
Баянцагаан	86,1	8,1	82,2	95,9	103,1	16
Бүрэн	78,8	4,1	85,7	96,1	100,5	17
Өндөрширээт	73,4	22,3	75,2	71,1	100,6	18
Мөнгөнморьт	60,0	25,5	86,1	66,1	100,0	19
Лүн	81,6	18,9	83,4	88,5	94,4	20
Эрдэнэсант	86,4	6,2	81,2	82,4	98,0	21
Эрдэнэ	83,0	15,1	80,9	65,2	80,4	22
Аймгийн дүн	89,5	38,8	84,3	88,3	100,3	

Статистикийн товчоо

ХӨДӨЛМӨРЧДИЙН ХУРЛЫН БҮТЭЭЛЧ ЧАНАРЫГ ДЭЭШЛҮҮЛЬЕ

Хөдөлмөрчдийн хурлыг 1970 оноос эхлэн аймгийн хэмжээгээр сайн зохиож хурлаар хэлэлцэх асуудлыг төлөвлөгөөтэйгээр явуулж ирлээ.

Хөдөлмөрчдийн хурлаар улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилт, иргэний үүргийн биелэлт, гэмт хэрэг зөрчилтэй тэмцэх, социалист эмчийг хамгаалах, мал өсгөх боломж нөөцийг дайчлах, төл хүлээн авах, өвлийн бэлтгэлийг хангах, мал оторлолтыг зохион байгуулах, хот сууринг тохижуулах, социалист уралааныг өрнүүлэх зэрэг чухал асуудлуудыг хэлэлцүүлсэн байна. Баянжаргалан, Борнуур, Угтаал, Баяндэлгэр зэрэг сумд хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлэх асуудлаа төлөвлөгөөтэй явуулдаг болсноос аж ахуйн зорилтыг шийдвэрлэх, байгууллагын ажлыг сайжруулахад гол асуудлаа чиглүүлэн хөдөлмөрчдийн хуралдаа

идэвхтэй оролцдог болгосон байна.

Хөдөлмөрчдийн хурлыг аймаг, сумнаас төлөөлөгч томилон удирдаж асуудлыг нэгэн зэрэг хэлэлцэж шийдвэрлэдэг болов.

Хөдөлмөрчдийн хурал хийх журам тогтоож, хүмүүсийг өөрсдөө идэвхтэй бэлтгэж оролцдог болгон даалгасан үүрэг даалгаврыг биелүүлэх хувь хүний үүрэг хариуцлагын тухай хэлэлцдэг ажиллагаа ихэнх суманд нэвтэрч байна.

Тус аймгийн олонхи сумд хөдөлмөрчдийн хурлыг улиралд 1-ээс доошгүй удаа тогтмол хийж байгаагийн гадна аймгийн хэмжээгээр 1974 оны аж ахуй, соёлыг хөгжүүлэх төлөвлөгөө, социалист уралдаанд үүрэг амлалт авахуулах тухай хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлэв. Мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлэх тухай 1973 оны 11 дүгээр сард аймгийн Намын хороо, АДХ-ын гүйцэтгэх захиргаанаас онцгой даал-

гавар гаргаж хөдөлмөрчдийн хурлаар хэлэлцүүлж үүрэг амлалт авахуулж ажилласан нь үр дүнд хүрч аймгийн хэмжээгээр мал өсгөх улсын төлөвлөгөөг биелүүлсэн юм.

Гэтэл хөдөлмөрчдийн хурлыг зохион байгуулж олгтой хийлгэхгүй нам, засгаа тавьж байгаа тухайн зорилтыг хэрэгжүүлэх арга замыг хөдөлмөрчидтэйгээ хамтран хэлэлцэж үрилцахгүй, бүрэн ойлгуулахгүй байгаагаас зарим сумдын ажил жигд сайжирч чадахгүй байна.

Энэ онд хөдөлмөрчдийн хурлыг муу зохион байгуулж хөдөлмөрчдийн хангалтгүй оролцуулсан асуудал Баянцогт, Баянцагаан, Баян-өнжүүл, Лүн, Эрдэнэсант сумдад гарч Өндөрширээт, Эрдэнэ, Мөнгөнморьт сумд хөдөлмөрчдийн хурлыг бригадын өдөрлөгөөр төлөөлүүлж өнгөрүүлдэг дутагдал үзэгдэв.

Иймээс хөдөлмөрчдийн хурлыг чанар сайтай зохион байгуулалттай хийл-

гэх удирдлага зохион байгуулалтын нэг арга болгон явуулж хөдөлмөрчдийн бүтээлч идэвхийг өрнүүлэн ажиллуулах хэрэггүйр болгох нь чухал. Хөдөлмөрчдийн хурлыг сумдад улиралд 1-ээс доошгүй удаа тогтмол хийж улс ардын аж ахуй, соёлын төлөвлөгөөт зорилт, социалист уралааны үүрэг амлалтын биелэлт, иргэний үүргийн биелэлтийн тухай асуудлыг заавал хэлэлцүүлдэг явдлыг журам болгон хэрэгжүүлж нам, засгийн тогтоол, шийдвэрийн биелэлтийг тухай бүр хэлэлцэж байвал зохино.

Хөдөлмөрчдийн хурлыг зохион байгуулалттай хийлгэх арга барилыг боловсронгуй болгож, хурлын хүмүүжүүлэх үүргийг дээшлүүлж, хурлын протоколь хөтлөлтийг сайжруулах, биелэлтийг дараагийн хуралд заавал сонгож байх журмыг баримталж, хөдөлмөрчдийн санал шүүмжлэлийг өргөн гаргуулж, мөрөөр нь то-

дорхой арга хэмжээ авч дутагдлыг дор нь шуурхай засч, туршлагыг нэгтгэн дүгнэж нийтийн хүртээл болгох ажлыг өргөн зохиох нь чухал байна.

Хөдөлмөрчдийн хурлыг зохион байгуулж хийлгэх ажлыг сум, хот, хорооны АДХ-ын гүйцэтгэх захиргаа, тасаг, бригад, гудамж, орон сууцны хороод, албан үйлдвэрийн газруудын захиргаанд дарга, эрхлэгч нар хариуцан гүйцэтгэж хэлэлцсэн асуудлын биелэлтийг дүгнэж байх нь зүйтэй юм.

Хөдөлмөрчдийн хурлын бүтээлч ажиллагааг дээшлүүлэн, хөдөлмөрчдийн эрэлт хүсэлт саналаа солилцох, байгууллагын ажлыг сайжруулахад чиглүүлэн малын зүй бүсын хорогдлыг багасгах, бод малын өсөлтийг хангах, социалист эмчийг хамгаалах, өр авдаггүй барагдуулах, хадлан гэжээл бэлтгэх, өвлийн бэлтгэлийг хангах зэрэг асуудлыг цаг алдалгүй хэлэлцэж ажил хэрэг болгох зорилт тавигдаж байна.

Г. НДМБҮҮ

Аймгийн нэгдсэн больницын давхар саарал байшингийн 210 цонх үдшийн гялаан гарахаас үүрийн цолмон мншээх хүртэл нэг ч гэрэл анивчихгүй байх ажээ.

Тиймээ! Тэнд зөвхөн нэг ээлжинд л гэхэд 80 хүн, хүний амь насны төлөө мэдлэг авчлааа зориулж ажилладаг цагаан халалтай бүсгүйчүүд албаны дүрэм ёсоор жижүүрийн эмчид хариуцсан тасаг бүрийнхээ өвчтөний байдлыг мэдэгдэж хаана аль тасагт ямар өвчтөнд тусламж үзүүлэх хэрэгтэйг мэдэгдсэнээр тус больницын ажил явагддаг.

Чухамдаа их хотын хөл дарагдсан амгалан шөнийн нойронд амсхийх даггүй ажил өрнөж байдаг газар энэ ажээ.

Хорвоод шинэ хүн... Нэгэн залуухан бүсгүй түргэн тусламжийн цагаан тэрэгнээс түшүүлсээр буулаа.

Хорвоод мөндлөх шинэ хүний амгалан царайг хэнээс ч түрүү халиах азтай төрсөн албанд зүтгэх төрөхийнхэн тэр бүсгүйг угтан авав.

Энэ тасгийг БНМАУ-ын гавьяат эмч Г. Дуламжав хариуцдаг.

Сурвалжлага бичих мөчид мөндөлсөн тэр шинэ

хүн Дуламжав эмчийн эх барьж авсан хэдэн мянга дахь хүүхэд ч байж болно. Харин нэгдсэн больницын төрөх тасагт 1974 онд мөндөлсөн 671 дэх шинэ хүн энэ юм.

Анхныхаа үрийг алжаалгүй амархан төрүүлээ.

Алтан гартай эмч Дуламжав, сувилагч эх баригч Дуламсүрэн, Намсрай, Нэргүй нартаа гялайлаа гэх буюу, би 11 дэх удаагаа энэ эмчийн гар дээр үрээ төрүүлсэн хүндээ гэх мэт

Учир нь гэвэл хаалгаар нь ормогч л хааяагүй бүүвэйн дуу уянгалах авай.

Шүрээ сайн хүүхэн Сурвалжлага хийсэн тэр өдрийн шөнө мээ заслалын өрөөнд нойргүй хонсон 5 хүний нэг нь Шүрээ хүүхэн байлаа.

Хэдий сайн мээ засалч байлаа ч сайн сувилагчгүйгээр мээ засал хийж чадна гэхэд бэрх.

Мээ засалч 2 гартай, хоёр гар хүрлэхгүй.

Дээр нь сувилагчийн

ЦАГААН НӨМРӨГТ БҮСГҮЙЧҮҮД

Сурвалжлага

сэтгэгдэл зузаан дэвтрийн хуудсанд бичигдсэн байх нь олонтой.

Энэ тасгийн хамт олон СХТ бригад байгуулан ажиллаж нэг ч хүүнийг гомдолгүйн төлөө гэсэн чин эрмэлзлэл төдий ажлын агуулга болжээ.

Монголын үзэсгэлэнт саран гуа Намайг төрүүлсэн ижийн Яруу сайхан эгшгээрээ Бөн бөн бүүвэлсэн ижийн Их зохиолчийн бичсэн уянгын энэ бадаг тус тасгаар ороход аргагүй санагдана.

10 хуруу хэрэгтэй болдог гэж мээ засалч Б.Батмөнх ярих дуртай.

Энэ үг үнэн ажээ. Шүрэнчимэг хүүхэн мээ заслалын тасагт сувилагчаар ажилласан сүүлийн 7 жил бараг хагас мянган хүнд мээ засал хийхэд хамт байлцжээ.

Шүрээ гэж нөхөд нь хүндэтгэн дууддаг энэ хүүхэн ахлах сувилагчийн хувьд өөрийн тасгийн бүх зүйлийг гардан удирддаг мээ заслалын тасаг аль ч тасгаас илүү цэвэрч дэглэм шаарддаг.

Тэр бүхнийг ян тан

байлгахад Шүрэнчимэг өөрөө үлгэрлэн нөхдөө зохион байгуулан ажиллуулж чаддагаас мээ заслалын тасаг нэгдсэн больницын хамгийн «Соёл» үйлчилгээтэй тасаг болжээ. Шүрэнчимэг ажиллахын зэрэгцээ бие даан сурч бага эмчийн мэргэжил эзэмшихээр мэрийж байна.

Мээ засал хийлгэх өвчтөн хагалгааны орон дээр гарах хүртэлх бүх бэлтгэлийг би хариуцдаг.

Үүнд уг мээ засалд ямар ямар багаж хэрэгсэлдэгх, гэрэл гэгээ ямар байх, өвчтөний сэтгэл санаа ямар байгаа зэрэг бүх асуудал хамаарна.

Тэр бүхэн бэлэн байхгүй бол мээ засал бэлэн болоогүй гэсэн үг.

Тэгэхлээр өвчин биднийг хүлээхгүй.

Бид л ажлаа хэзээд бэлэн зэлэн болгосон байх ёстой болдог гэж сувилагч Шүрээ ярьсан билээ.

Тиймээ. Тэгээд ч мээ заслалын сувилагч хүн техникийн өндөр мэдлэгтэй, сэтгэл зүйн сайн эмч байхыг шаарддаг аж.

Шүрээ тэр бүгдэд дадлага суусан хүн юм.

Тэгээд ч Шүрээ сайн хүүхэн шүү гэж нэгдсэн больницын хэн нь ч нэгэн саналтай хэлэх билээ.

Я. ЦЭВЭГ-ОЧИР



Баян сумын 8 жилийн дунд сургуулийн захиргаа сурагчдын зуны амралтаар өөрийн шөф Монгол—Польшийн найрамдал нэгдлийн дэргэд хөдөлмөр зүсэлн байгуулж саалинд ороогүй 100 үнээг фермийн аргаар сааж нэгдлийн үйлдвэрлэлд туслав.

Энэ ажилд багш Г.Лхагвасүрэн, Баасанжав, Батбаяр, Гүрцэрэн, сурагч Түвшинжаргал, Амаржаргал, Загдсүрэн, Чимэдсүрэн, Нэржмоо, Гантулга, Жавхлан нарын багш сурагчид саал сүү ашиглах өдөр бүрийн нормоо давуулан биелүүлж нөхдөө хошуучлав.

С. БУРМАА Батсүмбэрийн САА-н Д. Жадамбаа даргатай бригадынхан сүүлийн таван жил дараалан хадлангийн төлөвлөгөөг давуулж ирсэн туршлагаа бататган энэ жилийн хадлангийн төлөвлөгөөг 400 тонноор давуулан биелүүлэхээр социалист уралдаанд нэмэлт үүрэг авч Бургалтай, Шар Хоолой зэрэг ургац сайтай газар хадлан хадаж, хүмүүс өдөр тутмынхаа хийх ажлын нормыг давуулж байна.

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨЛТ

Улс ардын аж ахуйн хөрөнгө оруулалтад төлөвлөгдсөн объект нь улс ардын аж ахуйн үйлдвэрлэлийн ба үйлдвэрлэлийн бүс үндсэн фонд, төлөвлөгөөтэйгээр тасралтгүй нөхөч үйлдвэрлэхэд зориулсан улсын төвлөрсөн хөрөнгө, ах дүү социалист орнуудын зээл тусламж, төлөвлөлт эдийн засгийн урамшлын шинэ системээр ажиллаж байгаа үйлдвэр аж ахуйн байгууллагуудын үйлдвэр хөгжүүлэх фонд, ХАА-н нэгдэл, хоршоолсон байгууллагийн хувь нийлүүлсэн хөрөнгөөс бүрдэж санхүүждэг юм.

Манай орны улс ардын аж ахуйн түргэн хурдныг хангах зорилгоор хөрөнгө оруулалтын хөмжөө жил бүр тасралтгүй өсөв.

Улс ардын аж ахуйн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг шинжлэх ухааны үндэстэйгээр төлөвлөж салбаруудын хооронд зохиистой хуваарилах нь улс ардын аж ахуйн салбаруудын хоорондын тэнцвэрийг тогтоодог юм.

Манай нам засгаас улс ардын аж ахуйн тэргүүлэх гол салбарын техникийн дэвшилтийг хангаж, машин механизм тоног төхөөрөмжийг шинэчлэн өндөр хүчин чадалтай техник механизм төхөөрөмжөөр солиж тоноглох, технологийн процессийг сайжруулах замаар ах дүү социалист орнуудаас ирж буй машин механизм төхөөрөмжийг үйлдвэрлэлд нэвтрүүлэх хүчин чадлыг

бүрэн дүүрэн ашиглах зорилтыг тавьж байна. Ийм учраас хөрөнгө оруулалтыг төлөвлөхдөө манай орны эдийн засгийн хөгжлийг түргэтгэх, байгалийн нөөц баялагийг бүрэн ашиглаж аймаг, район, нийслэл засгийн хөгжлийг жигдрүүлэхэд чиглүүлнэ.

Хөдөө аж ахуйд худаг ус, усан сан, малын хашаа, тэжээл эмчлэгээний цэг зэрэг мал аж ахуйн тогтвортой өсөлтийг хангахад зориулагдсан барилгуудын байршилтыг зөв тогтоохгүй, чанаргүй барилга барих, нэгэнт буй болсон хөрөнгийг хүчин чадлын хэмжээнд хүртэл ашиглахын оронд ашиглалт, хамгаалалтгүй орхисноос улс хоршооллын ихээхэн хөрөнгө эвдэрч үрэгдэх явдал гарч байна.

Улс ардын аж ахуйн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдан үр ашгийн тооцоо бүрэн хийгдэж, техник эдийн засгийн үндэслэл бэлэн болсон объект үйлдвэрийг нормативт хугацаанаас өмнө чанар сайтай барьж байгуулах, өргөтгөн шинэ нэгдэх ажлыг хослон хийх нь хөрөнгө оруулалтын үр ашгийг дээшлүүлж, улмаар үндсэн фондын идэвхтэй хэсгийг нэмэгдүүлэн улс орны эдийн засгийн хөгжлийн хурдацыг түргэтгэхэд чухал үүрэг гүйцэтгэх учир хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулах нь чухал байна.

Н. ПУНЦАГ

ЭХ ҮРСИЙН ЭРҮҮЛ МЭНД

Манай улсын нийт эмнэлэг, урьдчилан сэргийлэх байгууллагуудын материаллаг бааз өсөн бэхжиж эх үрсэд үзүүлэх нарийн мэргэжлийн тусламж жилээс жилд улам өсч байгаагийн үр дүнд хүн амын цэвэр өсөлт нэмэгдэж улсын хэмжээгээр хүн амын 57.9 хувийг хорь хүртэлх насны хүмүүс эзлэх боллоо. Эх үрсийн эрүүл мэндтэй холбогдуулж, МАХН-ын Төв Хороо, БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс сүүлийн жилүүдэд гаргасан тогтоолуудад жирэмсэн эмэгтэйд үйлдлийг эмнэлгийн хяналтанд эрт авч, хөдөө аж ахуйн нэгдэл, САА-н дэргэдэх төрөхийн өмнө, хойно амрах байранд амруулж 100 хувь эмнэлэгт төрүүлж байх, 0—1 насны хүүхдэд эмч нарын давхар хяналтын систем тогтоох, асаргаа сувилагаа хоол тэжээлийн нөхцлийг сайжруулсны үндсэн дээр нялхсын өвчлөл эндэгдлийг тууштай бууруулахын чухлыг заасан билээ.

1974 оны байдлаар нийт эрүүлийг хамгаалах арга хэмжээний зардал 250 гаруй сая төгрөгт хүрч эх нялхсын байгууллагыг тохижуулах, тэдний эрүүл мэндийг сайжруулахад үлэмж хэмжээний хөрөнгө зарцуулж байгаа юм.

Манай нам засгаас эх үрсийн эрүүл мэндэд онцгой анхаарч байгалийн бас нэг тод ирлэл бол олон

хүүхэдтэй, одонтой эхчүүдийг үнэ төлбөргүй улсын амралтанд амруулах, төрсний дараах амралтыг нэмэгдүүлэх, эхийн одонгоор шагнах, хүүхдүүдэд нь зориулж мөнгөн тэтгэвэр олгох зэрэг арга хэмжээнүүд авч байгаа явдал мөн. 1973 оны байдлаар тус аймагт 4572 эх, эхийн одон авч, 24484 хүүхэд тэтгэвэрт хамрагдаж тэдэнд нийт дүнгээр 4,8 сая гаруй төгрөгийг олгосон байна.

Сүүлийн жилүүдэд тус улсад хүүхдийн эмнэлэг, төрөх тасаг, салбар, хүүхдийн цэцэрлэг, хүүхэд саа туулах газрууд олноор байгуулагдав.

Одоо тус аймгийн эмнэлгийн байгууллагуудын нийт орны 29,8 хувийг эх, хүүхдийн ор эзлэж, 1000 эх хүүхдэд ноогдох ор 1972 онд 7,9 байсан бол 1973 онд 8,5 болж өссөн байна.

Мөн жирэмсэн эмэгтэйд хүүхдэд зөвлөлгөө өгөх газар 12, хүүхдийн больниц 1, төрөх тасаг салбар 23, цэцэрлэг 29 тус тус ажиллаж байна.

1973 онд Зуунмод хот, Батсүмбэр сумын хүний их эмчийн салбар зэрэг нилээд газруудад жирэмсэн эмэгтэйдүүдийн зөвлөлгөөний ажиллагаа, 0—1 насны хүүхдийн хяналт тогтмолжиж чадсаны үр дүнд төрөхийн хүндрэл болон 0—1 насны хүүхдийн өвчлөл эндэгдэл тууштай буурчээ.

Гэвч өнгөрсөн онд Баян-

цогт, Жаргалант, Борнуур зэрэг сумдын салбарт дээрхи ажиллагаа хангалтгүй байснаас гадна сүүлийн жилд төрөхийн өмнө, хойно амрах байрыг ажиллуулаагүй байна.

Иймээс нийт эмнэлгийн байгууллагуудаас эх нялхаст үйлчлэх үйлчилгээг улам хөгжсөн шуурхай болгож эмэгтэйдүүд, хүүхдэд зөвлөлгөө өгөх газрын ажиллагааг чанаржуулж эмнэлгийн эмч ажилтан-ажилчдын ажлын үүрэг хариуцлагыг өндөржүүлж, түүнд гүйцэтгэлийн хяналт шалгалтыг байнга хийж байх хэрэгтэй юм.

Мөн эх нялхаст үйлчлэх үйлчилгээг улам боловсронгуй болгохдод эмнэлгийн байгууллагууд өөрсдийн ажлыг МХЗЭ, үйлдвэрийн, эмэгтэйдүүд, УЗН зэрэг олон нийтийн байгууллагуудтай хамтран зохиож байх нь чухал байна.

Нөгөө талаар эх нялхсын эрүүл мэндтэй холбогдуулж нам засгаас авч байгаа арга хэмжээний дагуу сум-нэгдэл, сангийн аж ахуйн дэргэдэх төрөхийн өмнө, хойно амрах байрын ажиллагааг тогтмолжуулах, 0—1 насны хүүхдийн амьдрал ахуй, хоол тэжээлийн нөхцлийг сайжруулахад төв орон нутгийн нам захиргааны байгууллагууд онцгой анхаарал тавивал зохино.

ЭХГ-ын эх нялхсын байцаагч, хүний их эмч М. ГҮРСЭД

ХУНТЫНХНЫ ЯЛТ АЖИЛЛАГААГ ЖИГШИН ЭСЭРГҮҮЦЭЖ БАЙНА

Фашист хунтынхан Чилийн ард түмний эсрэг балмад үйл ажиллагаагаа өргөжүүлж байгааг эсэргүүцсэн нам, улс, олон нийт, хөдөлмөрчид нэгдэлч, малчдын цуглаанууд тус аймгийн Зуунмод хот, Лун, Алтанбулаг сумдад боллоо.

Зуунмод хотод болсон эсэргүүцлийн цуглааны ажиллагааг хотын намын хорооны нарийн бичгийн дарга Ш. Доржпалам нээсний дараа аймгийн Намын хорооны үзэл суртлын хэлтсийн эрхлэгч Я. Дамдинсүрэн Чилид болж байгаа хэрэг явдлын талаар мэдэгдэл хийв.

Нөхөр Я. Дамдинсүрэн хийсэн мэдэгдэлдээ «Фашист хунт Чилийн ард түмний эсрэг цуст яргалал хүчирхийлээ улам өргөжүүлж байгаа жигшүүрт бузар үйл ажиллагааг даян дэлхийн дэвшилт улс түмний хамт Монголын ард түмэн түүний дотор тус аймгийн хөдөлмөрчид бил жигшин эсэргүүцэж, харгислалаа нэн даруй зогсоохыг хунтынханд шаардаж, Чилийн баатарлаг ард тү-

мэнтэй эв санааны нэгдэлтэй байгаагаа илэрхийлж байна.

Чилийн харгис хүчин, эх орончдыг зэрлэг балмадаар гэсгээн цээрлүүлснээрээ тэдний чин зоргийг мохоож хэрхэвч чадахгүй. Чилийн дэвшилт хүчин түр зуурын ялагдал хүлээсэн ч хойшид тэдний тэмцэл улам зохион байгуулалттай өндөр сонор сэрэмжтэй ган бат нэгдэлтэй өрнөй туйлийн зорилгоо биелүүлнэ гэдэгт бид итгэж байна.

Чилийн ард түмэн даян дэлхийн шударга хүн төрөлхтний дэмжлэгтэйгээр ялан дийлэх нь дамжиггүй юм гэж онцлон тэмдэглэв.

Мөн цуглаан дээр Чилийн эх орончид, ард түмэнтэй эв санааны бат нэгдэлтэй байгаагаа илэрхийлж аймгийн Барилга угсралтын конторын ҮЭ-ийн хорооны дарга Л. Хувцагаан, НААҮ-ийн газрын ажилчин Уртнасан, «Анхдугаар таван жил» сонинны ажилтан, сэтгүүлч Л. Гунгабуу нарын зэрэг хүмүүс үр хэллээ.

Ш. ЦЭРЭНДОО

КОММУНИЗМЫН ӨРНӨ АЖАЛ

ЭДИЙН ЗАСГИЙН ӨРНҮҮН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТ

(ЗСБНХУ улс ардын аж ахуйг хөгжүүлэх улсын төлөвлөгөөг 1974 оны эхний хагаст хэрхэн биелүүлсэн дүнгийн тухай ЗСБНХУ-ын Тоо бүртгэлийн Тов газрын мэдээний талаар)

Есдүгээр таван жилийн төлөвлөгөөний гурав дахь жил—1973 оны даалгаврыг амжилттай биелүүлсэн зөвлөлтийн эдийн засаг цаашид урагшлан ахиж, таван жилийн төлөвлөгөөний дөрөв дэх жил 1974 онд ч хөгжлийнхөө хурдыг улам түргэсгэн, ажлынхаа чанарын үзүүлэлтийг улам сайжруулж байна. Үүнийг энэ оны эхний хагасын дүн гэрчилж байна. Үүнд үйлдвэрлэл, хөдөлмөрийн бүтээмжийн хурд түргэсж, нийгмийн үйлдвэрлэлийн үр ашиг дээшиллээ.

Аж ахуйн гол салбар болсон аж үйлдвэр олонхи чухал бүтээгдэхүүн үйлдвэрлэх, борлуулах хагас жилийн төлөвлөгөөг давуулан биелүүллээ. Аж үйлдвэрийн үйлдвэрлэл поднигний эхний хагас жилтэй харьцуулахад 8,3 хувиар өслөө. 6,8 хувиар өсгөх төлөвлөгөөтэй байсан билээ. Дээрх хурд есдүгээр таван жилийн төлөвлөгөөний жилийн дундаж даалгавраас давж байна. Хөдөлмөрийн бүтээмжийг жилдээ зургаан хувиар өсгөхөөр төлө-

лөсөн бол өнгөрсөн хагас жилд 6,8 хувиар өслөө. Бүтээгдэхүүний өсөлтийн 83 хувийг хөдөлмөрийн бүтээмж ихэсгэх замаар бий болгов.

Бүтээгдэхүүний өөрийн өртөг хямдрав.


Аж үйлдвэрийн ашгийн төлөвлөгөө биелж, поднигний эхний хагас жилтэй харьцуулбал 12 хувиар өсөв.

Зөвлөлтийн аж үйлдвэрийн эдгээр амжилт нь газар тариалан, мал аж ахуй, тээвэр холбоо, их барилга зэрэг аж ахуйн бусад чухал салбарын амжилт ололтын найдвартай үндэс болж өгөв.

Эдийн засаг өрнүүн хөгжин, үндэсний орлого ихэссэн нь эхний хагас жилд хүн амын аж байдлыг улам сайн сайхан болгох талаар шинэ арга хэмжээ авах боломж олгов. Ажилчин, албан хаагчдын сарын дундаж цалин 4,8 хувиар, хамтралчдын хөдөлмөрийн хөлс 6 хувиар өсөв.

Тэгэхэд эд бараа, үйлчилгээний үнэ тогтвортой хэвээр байна, 1974 оны долоодугаар сарын нэгийг байдлаар ЗСБНХУ-ын нийт хүн ам 252 сая болсон байв.

(АПН)



НЭГЭН БҮЛГИЙН АЖЛЫН АРГААС

Борнуурын САА-н ХБА-ийн ҮЭ-ийн бүлгийн зохион байгуулагч Н. Цэенхорол ҮЭ-ийн бүлгийн бүх гишүүдийн хурлыг тогтмол хийж, ажлаа жилээр төлөвлөн түүнийхээ үндсэн дээр улирлын ажлын төлөвлөгөөтэй ажиллаж гаргасан тогтоол, төлөвлөгөөнийхөө биелэлтэй гүйцэтгэлийн шалгалт байнга хийж үр дүнг бүх гишүүдийн хуралд танилцуулан дутуу буюу биелэгдээгүй зүйлийг нөхөн биелүүлэх тодорхой ажил зохиодог байна.

ҮЭ-ийн бүлэг түшиглэсэн байгууллагатай ажлаа нягт холбож ХБА-ийн ажиллагаанд эдийн засгийн дүн шинжилгээ судалгаа хийж доголдох байгаа ажлыг засахын тулд хурлаар хэлэлцэн тодорхой шийдвэр гарган ажилладаг нь үр дүнд хүрчээ. Бүлгийн бүх гишүүдийн хурлаар түүнийг эд бэлтгэлийн явц, эдха-

риуцагчдын хариуцлага ногоо тариал хураалтын үеийн худалдаа үйлчилгээ, социалист уралдааны үүрэг амлалт, түүний биелэлт, үр нөлөө, дежурын дэлгүүр барьж хөдөлмөрчдийн эрэлт хүсэлтийг хангах зэрэг тодорхой асуудал хэлэлцжээ.

Дежурын дэлгүүрийг барихын тулд СХБ-ын хүчээр идэшний ногоо тарьж хуримтлал бий болгох шийдвэр гаргаж түүнийг гээ биелүүлж дэлгүүр барьж ашиглалтанд оруулсан нь хөдөлмөрчдийн талархал хүлээлээ.

Мөн байгууллагын сар, улирал, жилийн төлөвлөгөөт ажлын явцад дүгнэлт хийж, дутуу зүйлийг биелүүлэх талаар өндөр бүтээлийн ажлыг үе эе зарлан дүгнэх зэргээр бэлтгэлийн зүйлийг биелүүлэхэд бүх гишүүдийн хүчийг чиглүүлэн ажилладаг нь үр дүнд хүрчээ. Социалист уралдаанд

салбар агентууд, хүн нэг бүрийг хамруулан ажлаа 1000 баллаар байнга дүгнэж ажиллан, ангиараа СХБ-ийн хамт олон болжээ.

Ингэж түшиглэсэн байгууллагын ажилд биелсэн туслаг ажилчдийн үр дүнд ХБА-ийн үйлчилгээний ажил сайжран төлөвлөгөөт зорилт нь хугацаандаа чанар сайтай давж биелэгддэг байна.

Тус сумын ХБА нь 1973 онд 33 нэр төрлийн төлөвлөгөөт зорилтоос 31-ийг 101—137 хувиар биелүүлж аймгийн ХБҮГ-ын хэмжээний социалист уралдаанд 2 дугаар байр эзлэн байрын бичиг 1200 төгрөгийн шагнал хүртжээ. ҮЭ-ийн энэ бүлэг идэвхтэнүүдэд заавар зөвлөлгөөг сард нэг удаа өгч ажлы нь дүгнэн, дараа сард хийх ажлыг хэлж төлөвлөгөөнд нь тусгах ялтгал сонголтыг бүлгийн хурлаар хэлэлцэн заалт өгч ажилладаг.

Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одонт Беларуссын авто машины заводын үйлдвэрлэн гаргадаг машинууд алдартай билээ.

Тус завод суулийн үед „Белаз“ авто машины хүчин чадлыг сайжруулж 1200 моторны хүчтэй, 120 тоннын даацтай болгожээ.

ЗУРАГ ДЭЭР;
„Белаз“ машинууд
ТАСС-ын гэрэл зураг

Идэвхтэн тус бүрийн ажлын тайланг хагас жилээр гаргуулж бүх гишүүдийн хурлаар хэлэлцүүлэх, ажилдаа мөрдөх хууль дүрмийн жагсаалт гарган судлуулах, хийсэн ажлыг нэгний нөгөөгөөр шалгуулж дүгнүүлэх зэрэг ажил зохиосон нь тэдний ажлыг жигдрүүлэн сайжруулахад ач тусгаа өгчээ.

Ажилчин албан хаагчдын ерөнхий боловсрол мэргэжлийн системтэй дээшлүүлэх зорилгоор тусгай судалгаа хийж, түүнийхээ үндсэн дээр ажилчдын мэргэжил, боловсролыг дээшлүүлэх төлөвлөгөө боловсруулж түүнийг мөрдөн 1974 онд бага ангийн боловсрол 4 хүнд, бүрэн бус дунд боловсрол 3 хүнд олгох гэж байна. Н. Цэенхоролд энэхүү уйгагүй ажиллагааны үр дүнд тус бүлэг байдэвхтэний ажил жигд сайжирчээ.

Д. ДУЛАМЖАВ

Сонинд ирсэн захидал

Арга хэмжээ авууштай

Бүрэн сумын «Бүрэндэлгэрэх» нэгдэл сууриудад өгөх үйлдвэрлэлийн даалгаврыг 4 дүгээр сард хийж сууриудад хагас дутуу гардуулсан боловч биелэлт, явц, малын ашиг шимийг тооцох явдал хангалтгүй байгаагаас болж нэгдлээс улсад бэлтгэх бодын хөөвөр, хялгас, ямаа тэмээний ноос, уртын ноос нь төлөвлөгөө одоо болтол биелэгдээгүй тасарчээ. Тус нэгдлийн ямар суурь малчинаас хэдэн кг ноос дутуугаа мэдэхгүй байгаагаас болж сумын хэмжээгээр бодын хялгас 44 кг, хөөвөр 513 кг, ямааны ноос 134 кг, тэмээний ноос 715 кг, уртын ноос 20,6 мянган тонн дутуу байна.

Иймд анхан шатны тооцоо тоо бүртгэлийн хөдөлтийг сайжруулж, улс ардын, аж ахуйн төлөвлөгөөт зорилтыг биелүүлэхэд бүртгэлээр тавих хяналтыг эрс өндөржүүлж улсын төлөвлөгөөт зүйлүүдийг графикт хугацаанд нь биелүүлэхэд зохион байгуулалтын тодорхой арга хэмжээ авах цаг болжээ.

С. ДАШДЭНДЭВ

ХАРИУЦЛАГАТАЙ ЭРХЛЭГЧ

Д.ТОВУУ